БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Ф.МӨНХБАЯР

2025 оны 04 дүгээр сарын 17-ний өдөр

Буянбат

2025.04.17

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Тендер шалгаруулалтын нэр: Говь-Алтай аймгийн Жаргалан сумын төвд худаг шинээр гаргах
1.1. Тендер шалгаруулалтын дугаар: ГААХААГ/20250201109
2. Ажлын тодорхойлолт
2.1. Худгийн өрөмдөлгийн болон барилгын явцын үеийн болон болон дараах үеийн гэрэл зургийг авч, худгийн солбилцолыг тодорхойлсон байх
2.2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэх
2.3. Худаг шинээр гаргахад худгийн барилга дотор усан сан байгуулах ажлыг тендерт оролцогч хариуцаж гүйцэтгэнэ.
3. Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 15 ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засврлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмшүүлэх, ашиглах нийтлэг журмыг мөрдөнө.Үүнд :
3.1. Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт, туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр, суурилуулах, худгийн барилга зэргийг барьж байгуулна.
3.2. Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах тухай аймаг нийслэлийн ажлын хэсгийн акт №1-ийн дагуу ажлын төрөл хэмжээ өртгийг тогтооно.
3.3. Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, хүлээлгэн өгсөн тухай аймаг нийслэлийн ажлын хэсгийн акт, №2-ыг үйлдэж сумын комисст хүлээлгэн өгч, орон нутгийн өмчид тусгуулна
3.4. Худаг гаргахдаа өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ.
3.5. Худгийн цооног өрөмдөлгийн ажлын талаарх мэдээллийг өрөмдөлгийн ажлын журналд тэмдэглэнэ.
3.6. Өрөмдөлгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ
3.7. Ашиглалтын цооногийн техникийн пастортыг хөтөлж сумын ЗДТГ-т хүлээлгэн өгнө.
3.8. Инженерийн хийцтэй худгийг шинээр гаргасан далд ажлын тухай аймаг нийслэлийн ажлын хэсгийн акт №3-ыг үйлдэж эзэмшигчид хүлээлгэн өгнө.
3.9. Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт суурилуулна.Худгийн усны шахуурга нь ISO-9001 чанарын стандарт, гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон улсын гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон улсын гэрчилгээтэй байна.
4. Усны химийн болон бактерологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн байна.

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Б. Р МӨНХБАЯР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

2025.04.17

Буянбат

№	Үзүүлэлт	Тендерт оролцогчдын санал
1. Цооногийг өрөмдөх, цооногийг тоноглох		
1.1.	Цооног ашиглалтын ундарга: 0,8л/с ба түүнээс дээш	
1.2.	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна	
1.3.	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна	
1.4.	Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /Хүйтний улиралд тэсвэртэй/	
1.5.	Тунгаагуурын гүн нь 2 м-ээс багагүй	
1.6.	Усны чанарын сорил авах, шинжилгээ хийлгэх	
1.7.	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцорын хольцгүй, мөлхлөгийн хэмжээ нь 10-15мм-ээс томгүй байна	
1.8.	Цооногийн гүн нь 100 метрээс доошгүй байна	
2. Худгийн насос, цахилгааны утас хянах самбар		
2.1.	Гүний насос: ISO-9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой	
2.2.	Цахилгааны утас: 3 салаа, худаг ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн, залгаасгүй, ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно. /Туузаар ороож болохгүй/	
2.3.	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ашиглаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/, гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагуртай байна.	
3. Худгийн барилга		
3.1.	3*3*2 хэмжээтэй барилга, хаалга, цонхтой байна.	
4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгнө		
3.1.	Талбайг цэвэрлэх	
3.2.	Худаг, гүний насос ажиллуулах талаар сургалт хийх	
3.3.	Худгийн паспорт бэлдэх	